МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭРГЭН ТОЙРОНД ӨРНӨСӨН ҮЙЛ ЯВДЛУУД

12-Р САР

ОНЦЛОХ ХУУЛИУД

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ УУЛИЙГ БАТЛАВ

Засгийн газраас УИХ-д яаралтай хэлэлцүүлэх горимоор өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирэх оны төсвийн тухай хуульд бүхэлд нь тавьсан хоригтой холбогдуулан энэ хуулийн төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд Төсвийн тухай хуульд “Төсвийн төслийг дахин мэдүүлж, батлах” гэсэн 32[1] дүгээр зүйлийг нэмж тусгалаа.

2024.12.03

https://www.parliament.mn/nn/63503/
https://www.parliament.mn/nn/63528/

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙГ АЛДАГДАЛГҮЙ БОЛГОЖ, ТӨСВИЙН ЗАРЛАГААС 2.3 ИХ НАЯД ТӨГРӨГИЙГ БУУРУУЛЖ БАТАЛЛАА

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2025 оны төсвийн хуульд бүхэлд нь хориг тавьсантай холбоотойгоор өмнөх хуулийг хүчингүй болгосноор Засгийн газраас ирэх оны төсвийн тухай хуулийн төслийг дахин өргөн мэдүүлсэн. Өмнөх хуулийн төсвийн зарлагаас нийт 2.3 их наяд төгрөгийг хасаж, 33.5 их наяд төгрөг байхаар эцэслэн баталлаа. Тодруулбал, 2025 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 33.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35.2 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 33.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35.2 хувьд хүрэв. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж, суурь тэнцэл дотоодын нийт бүтээгдэхүүний 3.3 хувийн ашигтай болж байгааг Сангийн яамнаас мэдээллээ.“Төсвийн төслийг дахин мэдүүлж, батлах” гэсэн 321 дүгээр зүйлийг нэмж тусгалаа.

2024.12.12

https://www.parliament.mn/nn/63628/

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БАТЛАВ

Уг хуулийн өөрчлөлтөөр нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээ авч, тухайн өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлэх зохицуулалтыг тусгажээ. Улсын дээд шүүхэд бүртгэлтэй нийт 37 нам байгаагаас 22 нь 2024 оны УИХ-ын сонгуульд, 12 нь орон нутгийн сонгуульд тус тус оролцжээ. Эдгээрээс өнөөдрийн байдлаар 7 нам дүрмээ шинэчилж, бүртгүүлэх хүсэлтээ Улсын дээд шүүхэд хүргүүлсэн байна.

2024.12.13

https://www.parliament.mn/nn/63632/

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН 2024 ОНЫ 04 ДҮГЭЭР ДҮГНЭЛТИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЛӨӨ

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж, хүлээж авлаа. Татварын ерөнхий хуулийн зарим хэсэг, заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн талаарх дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар танилцуууллаа.

2024.12.26

https://www.parliament.mn/nn/63740/

ДУЛААНЫ III ЦАХИЛГААН СТАНЦЫН ШИНЭЧЛЭЛИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТАЛЛАА

“Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон баталлаа. Нийслэл хотын дулаан хангамж хэрэглээний 32 хувийг, төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний 16 хувийг тус тус хангадаг Дулааны гуравдугаар цахилгаан станцыг хоёр үе шаттай өргөтгөн шинэчлэхээр төлөвлөжээ. Эхний ээлжид 50 МВт-ын дулааны станцыг шинээр барьж, дараагийн шатанд ашиглалтын хугацаа дууссан 48 МВт-ын станцыг буулган, суурин дээр нь 250 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцыг шинээр барихаар тусгажээ.

2024.12.27

https://www.parliament.mn/nn/63750/

ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ БАЙГУУЛАХАД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ БАТЛАВ

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондм Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлав. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах чиглэл батлагдсанаар төмөр замаар экспортлох ачааны хэмжээг жилд 30 сая.тн түүнээс дээш, Тавантолгойн ордын нүүрсний экспортын хэмжээг жилд 70 сая.тн хүртэл өсгөж, нүүрс борлуулалтын орлогыг жилд 1,5 тэрбум доллароор нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

2024.12.27

ХЭЛЭЛЦЭЭРТ ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, СОЁРХОН БАТЛАВ

Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон баталлаа. Уг хуулийн төсөл нь хоёр зүйлтэй бөгөөд хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах болон хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгажээ. Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Захирагч нарын зөвлөлөөс 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан тогтоолуудаар, тус хэлэлцээрийн 1 дүгээр зүйл болон 12.1 дүгээр зүйлд тус тус өөрчлөлт оруулжээ. Монгол Улс нь 2000 оны 7 дугаар сарын 26-ны өдөр Европын сэргээн босголт, хөгжлийн банкийг үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч, УИХ соёрхон батласнаар тус банкны 61 дэх гишүүнээр элсэн орсон. Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу дээрх хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлнэ.

2024.12.27

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

“АРДЧИЛСАН ҮНДСЭН ХУУЛИЙН ЭХИЙГ БАРИГЧ Б.ЧИМИД” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО

Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалангийн ивээл дор Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч Б.Чимид агсны 90 жилийн ойг тэмдэглэх хүрээнд болсон уг эрдэм шинжилгээний хуралд Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтнүүд, эрдэмтэн докторууд, академичид оролцож, олон сонирхолтой илтгэлийг хэлэлцүүллээ. Эрдэм шинжилгээний хуралд оролцогчид болон Б.Чимид агсныг Үндсэн хуулийн төслийг боловсруулж байх үед нь зөвлөхөөр ажилласан Азийн сангийн зөвлөх асан Том Гинзбург, Юрген Вилке нар АНУ болон ХБНГУ-аас видео мэндчилгээ ирүүлж, Монголын нэрт эрдэмтний тухай дурсамжаа хуваалцлаа.

https://www.parliament.mn/nn/63632/ **2024.12.13**

“БИДНИЙ ЭРХ, БИДНИЙ ОРОЛЦОО” ХӨТӨЛБӨРИЙН ТӨГСӨГЧДӨД ХҮНИЙ ЭРХИЙН СУРГАГЧ БАГШИЙН БАТЛАМЖИЙГ ГАРДУУЛАВ

Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос Хүний эрхийн дэд хороо, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, Хүний эрхийн Үндэсний Комиссто хамтран “Бидний эрх, бидний оролцоо” сургагч багшийн хөтөлбөрийг зохион байгууллаа. Гурван өдрийн турш үргэлжилсэн эрх чөлөөт нийгмийн үнэ цэн, хүний эрхийн талаарх мэдлэгийг түгээх, залуусыг хүний эрхийн хамгаалагч болгоход дэмжлэг үзүүлэх зорилготой энэхүү хөтөлбөрт их, дээд сургуулийн 100 гаруй оюутан хамрагдаж, хүний эрхийн сургагч багшийн батламжаа гардан авлаа.

https://www.parliament.mn/nn/63598/ **2024.12.10**

ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН, МОНГОЛЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХОЛБОО ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

УИХ-ын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал Д.Бумдарь, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров нар хамтран ажиллах санамж бичиг гарын үсэг зурлаа. Монгол Улсын Их Хурал хүн төвт, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн үзэл санааг төлөвшүүлэхийг зорьж байгаа бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд Монголын өмгөөлөгчдийн холбоо мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллахаар боллоо.

https://www.parliament.mn/nn/63671/ **2024.12.19**

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮНЭЭР САМДАНГИЙН ЭНХБААТАРЫГ ТОМИЛЛОО

Монгол Улсын шүүхийн тухай хуульд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг Улсын Их Хурал нээлттэйгээр нэр дэвшүүлж, сонгон шалгаруулсны үндсэн дээр нэр дэвшигчийн сонгол хийж томилохоор заасны дагуу Хууль зүйн байнгын хорооноос 21 хоногийн хугацаанд нэр дэвшигчийн хүсэлт, материалыг хүлээн авсан бөгөөд тус хугацаанд 2 хүн материалаа ирүүлсэн байна. Нэр дэвшигчийн сонсголыг 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж, Хууль зүйн байнгын хороны хуралдаанаар нэр дэвшигч Самдангийн Энхбаатарыг томилохыг дэмжсэн юм. УИХ-ын чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн 73.2 хувийн саналаар Архивын ерөнхий газрын даргаар ажиллаж байсан С.Энхбаатарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томиллоо.

https://www.parliament.mn/nn/63682/ **2024.12.20**

ПАРЛАМЕНТЫН МЭТГЭЛЦЭЭНИЙ 14 ДЭХ УДААГИЙН АВАРГААР “МОНАД” БАГ ТОДОРЛОО

УИХ-ын Тамгын газар, Монголын Мэтгэлцээний нэгдсэн танхимаас хамтран Парламентын мэтгэлцээний улсын аварга шалгаруулах 14 дэх удаагийн тэмцээнийг 2024 оны 12 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэ удаагийн тэмцээн нь анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ойн хүрээнд “ҮНДСЭН ХУУЛЬТ ЁС: ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ” сэдвийн хүрээнд өрнөж, шилдэг 36 баг өрсөлдөв. Үндсэний аваргын төлөө МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийн “Бэйст клуб”-ийн “Монад” баг, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн “Беркли клуб”-ийн “Дайралцаан” баг өрсөлдөж, “Монад” баг шалгарлаа.

https://www.parliament.mn/nn/63704/ **2024.12.20**

ЖАГСАГЧДЫН ШААРДЛАГЫГ ХҮЛЭЭН АВАВ

УИХ-ын Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат, УИХ-ын Тамгын газрын Хуулийн газрын дарга Д.Дондогмаа, УИХ-ын даргын зөвлөх, Ажлын албаны дарга Т.Төрболд, УИХ-ын даргын зөвлөх Н.Отгончимэг болон албаны бусад хүмүүс жагсагчдын төлөөлөлтэй уулзан, шаардлагыг хүлээн авлаа. Тэрхүү шаардлагад, УИХ-ын нэр бүхий гишүүдийн өргөн барьсан хуулийн төсөлд гадаадаас ажиллах хүч авахад хязгаарлалт тогтоохгүй байхаар тусгасан нь Үндсэн хуулийн тодорхой заалтуудыг зөрчсөнийг дурдаад, УИХ-ын гишүүд өргөсөн тангарагаасаа няцсан гэж үзэж буйгаа илэрхийлсэн байна. Тиймээс тэдгээр гишүүдийг эгүүлэн татах асуудлыг УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлэх тухай агуулгыг тусгажээ. Хуулийн дагуу судлан үзээд хариу өгөхөөр боллоо.

https://www.parliament.mn/nn/63715/ **2024.12.24**

“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ 5Ш АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД “ШИЛ” АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР” МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЛИЙГ СОНСЛОО

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаар” мэдээлэл хийлээ.

https://www.parliament.mn/nn/63775/ **2024.12.27**

УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

ТӨР, НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН Ж.САМБУУГИЙН МЭНДЭЛСНИЙ 130 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭХ ТУХАЙ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ ӨРГӨН МЭДҮҮЛЭВ

БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга асан, Бүрэн эрхт Элчин сайд, XX зууны төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан түүний алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор уг тогтоолын төслийг санаачилсан байна. Тэрбээр “Монгол төрийн мэргэн өвөө” хэмээн нэрлэгдэж, ард түмний гүн хүндэтгэлийг хүлээсэн, үлгэр жишээ төрийн зүтгэлтэн байсан бөгөөд төрийн ажлын өвөрмөц арга барил, манай орны эдийн засгийн түлгүүр салбар болох уламжлалт мал аж ахуйг зөв зохистой эрхлэх талаарх үнэ цэнтэй бүтээл, үзэл санаа залуу үеийнхэнд танилуулах, өвөмшүүлэх нь чухал ач холбогдолтой гэж төсөл санаачлагчид үзэжээ.

2024.12.13
https://www.parliament.mn/nn/63634/

ХАРХОРУМ ХОТЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ӨРГӨН БАРИВ

Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Н.Учрал, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь нар Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүллээ. УИХ-ын 2023 оны 07 дугаар тогтоолоор Орхоны хөндийд шинэ Хархорум хот байгуулахаар шийдвэрлэснээс хойш Архангай болон Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрийн 189,363 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зам тээвэр, эрчим хүч, инженерийн дэд бүтцийн хангамж, болон бусад бүтээн байгуулалтуудыг хэрэгжүүлэх төлөвлөлтийг хийжээ. Хуулийн төсөл нь 8 бүлэг, 38 зүйлтэй бөгөөд бүс нутгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, түүх, соёлын өвийг сэргээх, тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх, оршин суугчдад ая тухтай орчин бүрдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг тусгасан байна.

2024.12.20
https://www.parliament.mn/nn/63685/

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ӨРГӨН МЭДҮҮЛЛЭЭ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын дарга Д.Амарбаясгаланд өргөн мэдүүллээ. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 14 мега төслийг хэрэгжүүлэхэд 280 мянган ажлын байр шинээр бий болох тооцоолол гарчээ. Манай улсад жилд дунджаар 30-40 мянган дотоодын ажиллах хүчний хомсдол үүсдэг бөгөөд хууль санаачлагчид уг хомсдолыг нөхөж, хөрөнгө оруулалт, бизнес эрхлэлтийг нэмэгдүүлэхийн тулд уян хатан бодлого баримталж буйгаа онцлов.

2024.12.20
https://www.parliament.mn/nn/63683/

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ӨРГӨН МЭДҮҮЛЛЭЭ

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг өргөн мэдүүллээ. Хуулийн төсөл батлагдсанаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашиг малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон цаашаг идэвх ашигт малтмалын нөөц ашигласны нэмэгдүүлсэн тусгай төлбөрийг, мөн бусад хувилбараар орлуулснаас бий болсон орлогыг Ирээдүйн өв санд бий, Хуримтлалын санд төвлөрүүлж, иргэдэд эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх эх үүсвэрийг бодитой нэмэгдүүлэх боломжтой гэдгийг хууль санаачлагч онцолоо.

2024.12.25
https://www.parliament.mn/nn/63728/

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ӨРГӨН МЭДҮҮЛЛЭЭ

Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгаланд Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар өргөн мэдүүллээ. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл батлагдсанаар банк, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ, удирдлагад суурилсан үйл ажиллагаа сайжирна. Мөн зээлдүүлэгч эрсдэлгүй, зөв шийдвэрийг шуурхай гаргах боломжтой болж, банк санхүүгийн салбарын хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн хэмжээ буурна. Нөгөө талаас зээлдэгч өөрийн зээлийн түүхийг хянаж, санхүүгийн сахилга хариуцлага нэмэгдэж, эдгээрийг дагаад зээлийн хүү буурах боломж бүрдэнэ гэдгийг төсөл санаачлагч танилцууллаа.

2024.12.25
https://www.parliament.mn/nn/63726/

“ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧИД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ӨРГӨН БАРИЛАА

Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид нэмэлт оруулах тухай” тогтоолын төслийг өргөн барилаа. 2023 оны 7 дугаар сарын 7-нд батлсан Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар төмөр замын үйл ажиллагааг хянах Засгийн газрын агентлаг байгуулахаар заасан ч, УИХ-ын 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төмөр замын газар тусгагдаагүй орхигдсон байна. 2023 оны байдлаар төмөр замын ачаа тээвэр 36.1 сая тонн болж, 15 000 хүн 1115 км замыг хариуцан ажиллаж байгаа бол удахгүй ашиглалтад орох төмөр замуудтай нийлээд сүлжээний урт 4,200 км, ажиллах хүчин 50,000 болохоор тооцоолсон тул уг тогтоолын төслийг боловсруулжээ.

2024.12.25
https://www.parliament.mn/nn/63728/

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ ӨРГӨН МЭДҮҮЛЭВ

Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүллээ.
Хүний халдашгүй байх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хүрээнд мөрдөн байцаалтыг өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр явуулахгүй байх, хэрвээ өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр мөрдөн байцаалт явуулж нотлох баримт цуглуулсан, хэрэг хүлээлгэсэн тохиолдолд тухайн мэдүүлэг, нотлох баримтыг үнэлэхгүй байх, шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хойшлуулдаггүй байх эрх зүйн орчныг тодорхой болгох зэрэг заалтуудыг хуулийн төсөлд тусгажээ.

2024.12.27
https://www.parliament.mn/nn/63771/

“БАТЛАН ХАМГААЛАХЫН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ТЕХНОЛОГИ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ӨРГӨН МЭДҮҮЛЛЭЭ

Батлан хамгаалахын сайд, С.Бямбацогт “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлэв. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2022 онд Япон Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр хоёр орны харилцааг “Монгол Улс, Япон Улсын энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-д хүргэж, түвшинг нь ахиулсан. Энэхүү Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батласнаар хоёр улсын энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдана хэмээн Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт танилцууллаа.

2024.12.27
https://www.parliament.mn/nn/63769/

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ӨРГӨН МЭДҮҮЛЭВ

УИХ-ын гишүүн Ч.Лодойсамбуу, Б.Баярбаатар, Д.Энхтуяа, А.Ганбаатар нар Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барилаа.
Тус хуулийн төсөлд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг хасахаар зохицуулжээ. УИХ-аас 2020 онд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг нэмэлтээр оруулсан. Энэ гэмт хэрэг нь “нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” гэж объектив талын шинжээр тодорхойлогдсон нь 2002 оны Эрүүгийн хуульд байсан “гүтгэх” гэмт хэргээс өргөн агуулга, хүрээг хамарч байна. Дээрх нэмэлтээр үг гэмт хэргийг “олон нийтэд тараасан бол” гэж объектив талын шинжээр нь тодорхойлж, субьектив талын шинжийг бүрхэгдүүлэн, худал мэдээлэл нь “гүтаасан, гүтаах” зорилго, агуулга, шинжтэй байх эсэхийг бүрэн гүйцэд тодорхойлолгүй орхигдуулж, нэр томьёо, ойлголтын зөрүүтэй байдал үүсгэсэн байна хэмээн хууль санаачлагчид тодотголоо.

2024.12.27
https://www.parliament.mn/nn/63769/

УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООДООР

2024.12.18 https://www.parliament.mn/nn/63662/

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД “ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ” ХХК-Д АЖИЛЛАЛАА

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос байгуулсан “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааг шалган судлах, хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргаж, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд сайжруулсан түлшний үйлдвэрт ажиллалаа. Тус үйлдвэр “Энержи Ресурс” ХХК-ийн Ухаа худгийн уурхайгаас бүтээгдэхүүнийхээ үндсэн түүхий эд болох (мидлинг) баяжуулсан нүүрсний завсрын бүтээгдэхүүнийг төмөр замаар өдөрт 4000 тонныг татан авдаг. Төвийн болон зүүн үйлдвэрүүд сард 75000 тонн сайжруулсан түлш үйлдвэрлэдэг бөгөөд өртгөөсөө тав дахин хямд үнээр борлуулдаг. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа MNS 6226:2011, MNS 5679:2022, CS 11-0566:2024 зэрэг холбогдох стандартыг бүрэн хангаж байгаа, үйлдвэрлэлийн технологийн горим огт өөрчлөгдөөгүй, түүхий эдийн найрлагад өөрчлөлт ороогүй гэдгийг Ерөнхий технологич Д.Өлзийбат онцоллоо.



2024.12.19 https://www.parliament.mn/nn/63679/

АГААРЫН БОХИРДОЛ, УТААНЫ АСУУДЛААР ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙГ БАЙГУУЛЛАА

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэнгээр ахлуулан, УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Х.Баасанжаргал, Ц.Баатархүү, П.Батчимэг, Б.Баярбаатар, Г.Ганбаатар, Л.Мөнхбаясгалан, М.Мандхай, З.Мэндсайхан, Д.Найдалаа, Дам.Цогтбаатар, С.Лүндэг, А.Ундраа, Б.Уянга, С.Эрдэнэболд, С.Замира, М.Ганхүлэг нарын бүрэлдэхүүнтэй байгууллаа.

2024.12.23 https://www.parliament.mn/nn/63702/

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ ГИШҮҮД ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗАВ

УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны гишүүд хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөлтэй уулзаж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. УИХ-аас аливаа бодлогын шийдвэрийг гаргахдаа иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч ажиллах, зарим тохиолдолд парламентын хяналтын чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар зөвлөлдөх, олон нийтийг соён гэгээрүүлэх, хүний эрхийн боловсролыг УИХ-ын Хүний эрхийн дэд хорооноос хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөлтэй хийх уулзалтыг сар бүр зохион байгуулахаар товлож, хамтран ажиллах төлөвлөгөө гаргахаар боллоо.

ХУУЛЬ, ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН МЭДЭЭЛЭЛ

БОХХААБХ:

Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мэдээллийг сонслоо.

2024.12.10

https://www.parliament.mn/nn/63606/

https://www.parliament.mn/nn/63659/

АУББХ:

Үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын явцын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд нарын мэдээллийг сонслоо.

2024.12.17

ИЦББХ:

Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийн явцын талаарх Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээлэлтэй танилцлаа.

2024.12.18

https://www.parliament.mn/nn/63667/

https://www.parliament.mn/nn/63668/

БШУССБХ:

Боловсролын салбарын эрх зүйн орчин шинэчлэгдсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний ерөнхий мэдээлэл, боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн талаарх Боловсролын сайдын мэдээллийг сонсов.

2024.12.18

ЭЗБХ:

Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжих, цахилгаан эрчим хүчний тарифын өсөлт, эрчим хүчний хангамжийн тасралтгүй, найдвартай, аюулгүй байдлыг хангах талаар авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсов.

2024.12.19

https://www.parliament.mn/nn/63678/

https://www.parliament.mn/nn/63703/

Ажлын хэсэг:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн хуралдаанаар лавлагаа шатлалын эмнэлгүүдийн мэдээллийг сонслоо.

2024.12.23

Хамтарсан хуралдаан:

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанаар байгаль орчны салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонслоо.

2024.12.24

https://www.parliament.mn/nn/63719/

НЭГДҮГЭЭР САРД БОЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2025.01.08 Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийг баталсны 100 жилийн ойн хүрээнд “Ахмадын үндэсний чуулган” Төрийн ордонд болно.

2025.01.13 Монгол Улсын Үндсэн хуулийн өдөр

2025.01.13 Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимидийн нэрэмжит шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа Төрийн ордонд болно.

2025.01.14 Эдийн засгийн байнгын хороонoос
- Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн,
- Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн,
- Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн,
- Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн,
- Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд тус тус нэр дэвшигчидтэй хийх нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулна

Улсын Их Хурлын Тамгын газар.
Монгол Улс 14201 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Жанжин
Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон.

+976-51-267016
+976-11-327016

secretariat@parliament.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР © 2024.